| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5129000.00 | 5153000.00 | 6596300.00 | 6848500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6411400.00 | 6441400.00 | 6545400.00 | 6217400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1282500.00 | 1288500.00 | 1460200.00 | 1536000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12821000.00 | 12881000.00 | 14601800.00 | 14601800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47947400.00 | 47869783.00 | 52430700.00 | 52480400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14499800.00 | 14499774.00 | 16254200.00 | 16232400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25800000.00 | 27053426.00 | 27746800.00 | 28552333.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7647600.00 | 6316583.00 | 8429700.00 | 7695667.00 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39424400.00 | 39285272.50 | 36900900.00 | 36596877.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 10959600.00 | 10412920.00 | 10978100.00 | 10975495.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12699600.00 | 12695000.00 | 12699600.00 | 12699600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8260400.00 | 8065232.50 | 8260000.00 | 8090742.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 330000.00 | 185000.00 | 259200.00 | 128000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7174800.00 | 7927120.00 | 4704000.00 | 4703040.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5999200.00 | 6048200.00 | 5000000.00 | 5000000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5999200.00 | 6048200.00 | 5000000.00 | 5000000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 38315600.00 | 38279843.00 | 63369700.00 | 60398040.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6583500.00 | 6548000.00 | 0.00 | 0.00 |
| 210602 | Тавилга | 13732100.00 | 13731969.00 | 33369700.00 | 32400000.00 |
| 210604 | Урсгал засвар | 18000000.00 | 17999874.00 | 30000000.00 | 27998040.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1816500.00 | 1809951.00 | 294400.00 | 294400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1816500.00 | 1809951.00 | 294400.00 | 294400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10816900.00 | 10692480.00 | 3361200.00 | 2786400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3121200.00 | 2998280.00 | 3121200.00 | 2546400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180000.00 | 180000.00 | 240000.00 | 240000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7515700.00 | 7514200.00 | 0.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 443394000.00 | 439839214.36 | 383157200.00 | 381797705.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 443394000.00 | 439839214.36 | 383157200.00 | 381797705.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31980700.00 | 25685627.00 | 29250000.00 | 28424517.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.0 | 0.0 | 0.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31980700.00 | 25685627.00 | 29250000.00 | 28424517.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30480700.0 | 24185700.0 | 20250000.00 | 19792287.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1500000.0 | 1499927.0 | 9000000.00 | 8632230.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1346477800.00 | 1347799120.00 | 1395118500.00 | 1395078500.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1346477800.00 | 1347799120.00 | 1389918500.00 | 1389918500.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1346477800.0 | 1347799120.0 | 1389918500.00 | 1389918500.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 0.00 | 0.00 | 5200000.00 | 5160000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | 5200000.00 | 5160000.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **14** | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | 0.00 | 0.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.0** | **0.0** | 0.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **103595247.90** | **162007877.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **103595247.90** | **161856447.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 100978843.00 | 159356447.00 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.00 | 98923370.00 |
| 210104 | Урамшуулал | | 98923370.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 0.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2666254.00 | 5618398.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 2711618.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1661680.00 | 2906780.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 1352010.00 | 4505000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1052010.00 | 315000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 890000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3300000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 0.00 | 0.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 36217771.00 | 14990784.00 |
| 210602 | Тавилга | 16442900.00 | 3882000.00 |
| 210604 | Урсгал засвар | 19774871.00 | 11108784.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 0.00 | 0.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4785000.00 | 0.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 55957808.00 | 35318895.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55957808.00 | 35318895.00 |
| 2122 | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 0.00 | 0.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2616404.90 | 2500000.00 |
| 2131 | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.00 | 0.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 2616404.90 | 2500000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2616404.90 | 2500000.00 |
| 2133 | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.00** | **0.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **151430.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 0.00 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 0.00 | 151430.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 226001 | төвлөрүүлэх шилжүүлэг | | 151430.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **0.00** | **0.00** |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 101247379.90 | 162015377.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 101247379.90 | 162015377.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1500000.00 | 101570800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10401808.00 | 24492095.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 89345571.90 | 35952482.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга А.Наранцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 07-ноос 2021 оны 02 дугаар сарын 24-ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чанартай хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Санхүү хяналт дотоод аудитын албанаас 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,277,091.1 мянган төгрөгөөс тооцон 45,541.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 44,463.9 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119,987.3 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данснууд байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 0.0 | 158.8 | 158.8 |
| Урьдчилгаа | | | 0.0 |
| Бараа материал | 130,991.4 | 184,442.6 | 53,451.2 |
| Үндсэн хөрөнгө | 11,939,373.0 | 12,568,746.2 | 629,373.2 |
| Элэгдэл | -2,087,850.4 | -2,650,846.3 | -562,995.9 |
| **Нийт хөрөнгө** | **9,982,514.0** | **10,102,501.3** | **119,987.3** |
| Өр төлбөр | | 158.8 | **158.8** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 9,982,514.0 | 10,102,342.5 | **119,828.5** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **9,982,514.0** | **10,102,501.3** | **119,987.3** |

Авлага дансны үлдэгдэл 158.8 мянган төгрөг болж өөрчлөгдсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалингаас татвар суутган тооцсонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 184,442.6 мянган төгрөг болж 53,451.2 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын бараа материал мөн сумын аюулгүйн нөөц өвс жилийн эцэст авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,568,746.2 мянган төгрөг болж 629,373.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 727,997.1 мянган төгрөгийн, үдсэн үйл ажиллагааны давсан орлогоос 7,182.0 мянган төгрөгийн, бараа материалаас 11,000.0 мянган төгрөгийн, урсгал төсвөөс 32,400 мянган төгрөгийн

хөрөнгө орлогод авч 149,205.9 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэрээр акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 158.8 мянган төгрөг болж өөрчлөгдсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалингаас татвар суутган тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,102,342.5 мянган төгрөг болж 119,828.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 272,196.3 мянган төгрөгөөр буюу 10,4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орон нутгийн төсвийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан хөрөнгийн орлого байна. Энэ нь цар тахалтай холбоотой зарим хөрөнгө оруулалтын ажил буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 54,491.1 мянган төгрөгөөр буюу 2,4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт эд хогшил, урсгал засвар, томилолт, бараа үйлчилгээний бусад зардал буурсантай холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,395,118.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,395,118.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийг хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /код-70106/ хөтөлбөрийн 1 /код-80101/ арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,389,918.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,200.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор нийт 1,395,118.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс нийт 1,389,918.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 5,160.0 мянган төгрөг, нийт 1,395,08.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,388,631.8 мянган төгрөгийг зарцуулж 6,486.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,388,631.8 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байгаа нь эд хогшил, урсгал засвар, бараа үйлчилгээний зардлыг 6,486.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь цар тахалтай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 101,570.8 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 24,492.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 35,952.5 мянга, нийт 162,015.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 161,863.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 151.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого, эх үүсвэрийг төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 142 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, 18,896.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнө жилийн аудитаар тогтоосон 10,0 сая төгрөгийн төлбөрийн акт төлөхөөс 8,1 сая төгрөгийг төлж 1,9 сая төгрөгийг дутуу төвлөрүүлж 80,6 хувийн биелэлттэй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,639.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 158,8 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,920.0 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 9,560.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.

#### Залруулсан алдаа

Аудитаар 158.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоололтой холбоотой алдаатай асуудал гарсан тул залруулга хийгдсэн.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 146,507.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 146,507.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг шалгахад журамд заагдаагүй арга хэмжээнд 1,8 сая төгрөгийг зарцуулсан нь *Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2.1.5 дахь "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоов.

2. Төлөөлөгчийн газрын түрээсийн орлого 6,600.0 мянган төгрөгөөс төсөвт төвлөрүүлэх 40 хувь буюу 2,640.0 мянган төгрөг , УБХ-ын түрээсийн орлогын 40 хувь буюу 480,0 мянган төгрөг нийт 3,120.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "*Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна*", Дорнод аймгийн ИТХ-ын

Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 15-ны 50 дугаар тогтоолоор батлагдсан "*Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдан борлуулах, ашиглуулах, түрээслүүлэх журам*"-ын 5.14-т "*Түрээсийн орлогын 40 хувийг аймгийн төсөвт төвлөрүүлнэ*" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тулган шалгахад сумын Засаг даргын захирамжаар нийт 7,461.7 мянган төгрөгийн хөрөнгийг урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай болон журамд заагдаагүй арга хэмжээнд зарцуулсан нь *Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2 дахь "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйлс, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно"* гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4. Тус байгууллага нь 18,896.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг шилэн дансанд мэдээлээгүй нь Шилэн дансны 6 дугаар зүйлийн 6.4 дэх "*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*", 6.4.5 дахь "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв

5. Аудитын явцад харилцагч байгууллагуудтай хийсэн нийт худалдан авалт, төлбөрийн гүйлгээг татварын е-баримтын цахим системтэй тулган шалгахад 111,331.4 мянган төгрөгийн гүйлгээг е-баримтгүй хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.5 дахь хэсэгт "... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь заалт Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах" гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

6. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас 158.8 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган авсан нь ХХОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх "*Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө*", 22.1.2 дахь "*хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв

7. Өмнөх оны зөвлөмжийн биелэлтийг шалгахад 10,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт төлөхөөс 8,060.0 мянган төгрөгийг төлж 1,940.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байгаад Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дахь "*Энэ*

*хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ......... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”*, гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэв.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв

**Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | |
|---|---|---|
| Огноо: 2020 | Аудитын нэр: ***Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: ДОА-2021/81/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | ***Хэрлэн сумын ЗДТГ*** | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг шалгахад журамд заагдаагүй арга хэмжээнд 1,8 сая төгрөгийг зарцуулсан байна. | 1,800.0 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | А.Наранцэцэг Д.Алтансувд |
| 2 | Төлөөлөгчийн газрын түрээсийн орлого 6,6 сая төгрөгөөс төсөвт төвлөрүүлэх 40 хувь буюу 2,6 сая төгрөг , УБХ-ын түрээсийн орлогын 40 хувь буюу 480,0 мянган төгрөг нийт 3,1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна. | 3,120.0 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | А.Наранцэцэг Д.Алтансувд |
| 3 | Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тулган шалгахад зориулалт бусаар болон урьдчилан төлөвлөх боломжтой 7,4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна. | 7,461.7 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | А.Наранцэцэг Д.Алтансувд |
| 4 | Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг зөрчин таван сая төгрөгөөс дээших 2 гүйлгээг мэдээлээгүй | 18,896.0 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | А.Наранцэцэг Д.Алтансувд |
| 5 | Нийт худалдан авалт, төлбөрийн гүйлгээг татварын е-баримтын цахим системтэй тулган шалгахад 111,331.4 сая төгрөгийн гүйлгээг е-баримтгүй хийсэн байна. | 111,331.4 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | А.Наранцэцэг Д.Алтансувд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Өмнөх оны зөвлөмжийн биелэлтийг шалгахад 10,0 сая төгрөгийн төлбөрийн акт төлөхөөс 8,1 сая төгрөгийг төлж 1,9 сая төгрөгийг дутуу төлсөн байна. | 1,940.0 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | А.Наранцэцэг Д.Алтансувд |
| 7 | Цалин, тээвэр, томилолтын зардлыг анхан шатны баримттай нь тулган шалгахад ХХОАТ-ын хууль зөрчин хөгжлийн бэршээлтэй иргэдийн цалингаас татвар суутган авсан байна. | 158.8 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | А.Наранцэцэг Д.Алтансувд |
| **ДҮН** | | **144,707.9** | | | |